


УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, СААРУУЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ




ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ: УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, СААРУУЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ

СЭДВИЙН ЗОРИЛГО: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, түүний сөрөг нөлөөллийг бууруулах талаар мэдлэг олгох

АГУУЛГА:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ерөнхий ойлголт
- Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, дасан зохицох нь
- Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулах нь



“Уур амьсгал”

Тухайн газар оронд олон жилээр хэвшин тогтсон цаг агаарын дундаж нөхцлийг уур амьсгал гэнэ.

“Цаг агаар” Тухайн газар нутагт тухайн үед ажиглагдаж байгаа агаарын үзэгдлийг бүхэлд нь нийлүүлээд цаг агаар гэж нэрлэдэг.



Уур амьсгалын өөрчлөлт гэж

Дэлхийн уур амьсгал нь хэдэн арван мянган жилийн хугацаанд өөрчлөгдөж байдаг ба үүнд дэлхийн дотоод болон гадаад хүч зүйлс нөлөөлдөг боловч хүний үйл ажиллагаас болж сүүлийн үед зөвхөн орчин үеийн уур амьсгалын өөрчлөлт буюу дэлхийн дулаарал гэдэг утгаар хэрэглэж байна.



Хүлэмжийн үзэгдэл

А Г А А Р М А Н Д А Л



НАР

Нарнаас ирж буй
цацраг

240 Watt per m³

Агаар мандал болон
дэлхийн гадаргаас ойсон
цацраг

103 Watt per m³

Сансрын уудамд
алдагдах хэт улаан
дулааны цацраг

240 Watt per m³

ХҮЛЭМЖИЙН ХИЙНҮҮД

Газрын гадарга дээр ирж
байгаа нарны шууд цацраг

343 Watt per m³

Дулааны хэт улаан цацрагийн зарим хэсэг нь
хүлэмжийн хийн молекулд шингэж, дэлхий рүү
эргэн ойж, нэмэлт дулааралтыг бий болгоно.

Нарны цацрагийн нөлөөгөөр дэлхийн гадарга халж дулааны хэт
улаан цацрагийг туяаруулна.

Нарны энерги дэлхийд шингэж
түүний гадаргыг халаана.

168 Watt per m³

E A R T H

НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙ

үүсгэж буй

звйлс

Хөдөө аж ахуй



Хог хаягдал



Химийн үйлдвэрлэл



Үйлдвэрлэл



Шаталт




Ой мод устгал



Эрчим хүч




Дэлхийн хүлэмжийн хий ялгаруулалтын гол эх үүсвэрүүд:





- Цахилгаан, дулаан
- Аж үйлдвэр
- Ой газар ашиглалтын өөрчлөлт
- Хөдөө аж ахуй
- Тээвэр
- Барилга
- Хог хаягдал, бохир ус

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

2015 онд Улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн 371 хог хаягдлын төвлөрсөн цэгийн 3724,7 га талбайд нийт 2,3 сая тн хог хаягдал тээвэрлэж, зайлуулжээ.






2015 оны байдлаар нийт зайлуулсан хог хаягдлыг төрлөөр нь авч үзвэл, 90.9% нь ахуйн, 9.1% нь үйлдвэрийн хог хаягдал эзэлж байна.




Дэлхийн уур амьсгал 1880-2012 оны хоорондын 130 гаруй жилийн хугацаанд 0.85°C -аар дулаарсан

- ❖ Энэ өөрчлөлт дэлхий дээр аж үйлдвэрийн хувьсгал эхэлсэн 1750-аад оны үеэс эхтэй
- ❖ Гол шалтгаан нь хүний үйл ажиллагаа, агаарт их хэмжээгээр ялгаруулж байгаа хүлэмжийн хий, метан
- ❖ Монгол орны нийт нутгаар 1940 оны үеэс хойш агаарын температур 2.4°C -аар дулаарсан нь дэлхийн дунджаас даруй 3 дахин өндөр байна
- ❖ Мөн Монгол оронд сүүлийн 69 жилийн дотор хамгийн дулаан 10 жилийн 9 нь 1990 оноос хойш тохиолдсон байна. Халуун өдрийн тоо нэмэгдэж хүйтэн өдрийн тоо цөөрч, ургамлын ургалтын хугацаа 2-3 долоо хоногоор уртасчээ.
- ❖ Сүүлийн 73 жилийн дотор хамгийн дулаан 10 жил бүгд 1997 оноос хойш тохиолджээ.

Монгол дахь хүлэмжийн хийн ялгаралт





Эх үүсвэр: Олон улсын эрчим хүчний агентлаг





Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж буй нүүрсний хэмжээ, хувиар, 1990- 2016

Монгол орны хүлэмжийн хийн нийт ялгарал, салбараар, мян.тн. CO₂-эkv. /Эх сурвалж БОАЖЯ, 2014 он/



МОНГОЛ ОРНЫ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ЮУ ДАГУУЛАХ ВЭ?





АЛТАЙ ТАВАН БОГД 1905 он
Гэрэл зургийг Сапожников.В.В



АЛТАЙ ТАВАН БОГД 2007 он
Гэрэл зургийг Г.Даваа

Монгол улсын 2007 оны усны тооллогоор:

5128 гол горхийн 852 нь ширгэж, 9306 булгийн 2277 нь,

7474 нуур цөөрмийн 1181 нь,



429 рашаан усны 60 нь хатаж үгүй болжээ.

Өөрөөр хэлвэл манай орны гол горхины 16%, булаг шандын 21.8%, нуур тойрмын 28.0% нь ширгэжээ.

Гүний усны түвшин 3-5 м доошилж, мөнх цасны 40% нь хайлжээ.


Монгол орны уур амьсгалын ирээдүйн хандлага

Уур амьсгалын өөрчлөлтийн прогнозоор ирээдүйд энэхүү дулааралт эрчимжин үргэлжилнэ. Жишээ нь жилийн дундаж температур 6°C -аас дээш байх газар нутгийн хэмжээ манай орныг бараг бүхэлд хамрахаар байна.




Агаар мандлын гаралтай гамшигт үзэгдэл

Ус, цаг агаарын аюултай үзэгдлүүдийн тоог төрөл тус бүрээр нь сүүлийн 2 арван жилээр харьцуулсан байдал




Агаар мандалын гаралтай гамшигт үзэгдэл

Аюултай үзэгдлийн төрөл, 2001-2015



Аюултай үзэгдлийн хандлага



Аюултай үзэгдэл


- Хүчтэй салхи, аадар бороо, аянга цахилгаан 81%.
- Гамшгийн хохирлоор ган, зуд, ой хээрийн түймэр, цасан шуурга, үер гэж эрэмбэлэгдэнэ.
- Сүүлийн 20 жилд эдгээр аюултай үзэгдлийн давтагдал үндсэндээ 2 дахин нэмэгдсэн.
- Ойролцоогоор дунджаар жилд 50-70 тэрбум төгрөгний хохирол учруулдаг.



ЭЕРЭГ ҮР ДАГАВАР

- Өвлийн хүйтний эрч сулрах;
- Хавар эрт эхэлж, намар оройтох;
- Гол горхи, нуур цөөрөм орой хөлдөж, эрт гэсэх;
- Ургамлын ургах боломжит хугацаа уртсах;
- Дулаасаг мод бут, өвс ургамал нутагших нь ихсэх;
- Нүүдлийн амьтад, шувууд буудаллах, байрших хугацаа сунгуу болох;
- Таримал ургамлын төрөл олшрох боломж нэмэгдэх;
- Галлагааны хугацаа богино болох.

ДАСАН ЗОХИЦОХ ГЭДЭГ НЬ




ДАСАН ЗОХИЦОХ ГЭДЭГ НЬ

Уур амьсгалын өөрчлөлтийн бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаварт байгаль нийгмийн өртөх байдлыг бууруулах, эсвэл эерэг нөлөөлөл, аятай таатай нөхцлийг аль болох бүрэн дүүрэн ашиглахад чиглэсэн хүний үйл ажиллагаа, арга хэмжээ юм..



**ГЭРЭЭСЭЭ ГАРАЛГҮЙГЭЭР УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ
ТЭМЦЭЖ БОЛНО.**




Бид уур амьсгалын
өөрчлөлтийн эсрэг
юу хийж чадах вэ?



Би чадах
юм байна





Эрчим хүчний хэмнэлт

Гэрэлтүүлэг:

- Та эрчим хүчинд үр ашигтай технологийг ашигласанаар гэрэлтүүлэгт зарцуулдаг эрчим хүчний зардалаа 50%-иар багасгах боломж бий. Үүний тод жишээ нь улайсдаггүй чийдэн бөгөөд та үүнийг ашигласанаар жилд 68,1 кг нүүрстөрөгчийн давхар исэл агаарт ялгарахаас сэргийлнэ. Энэхүү гэрэлд мөнгөн ус агуулагддаг учир хагалж тоглох аюултайг анхаарах хэрэгтэй.
- Өрөөний өнгөө цайвар болгох нь гэрлийн 80%-ийг ойлгох ба бараан өнгө нь ердөө 9-15%”ийг ойлгодог байна.
- Гэрлийн шилийг сайтар арчиж байх. Тоостой байх нь 10-15%-ийг бууруулдаг байна.
- **Эрчим хүчний хэмнэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах**

A хамгийн бага

G хамгийн их

(B-гээс доош бол хэрэглэхгүй байх)



БАЙР ОРОН СУУЦАА ДУЛААЛАХ

- Халаалт: Ойролцоогоор өрх айлын эрчим хүчний хэрэглээний 38% нь халаалт болон хөргөлтөнд зарцуулагддаг. Дээвэр, хана, цонхоор их хэмжээний дулаан алддаг. Жишээ нь өвөл гэрийн дулааны бараг 40%-ийг алддаг учир гэр, сууцны дулаалгыг сайтар хийж байх.
- 10 см зузаан ноос нь дулаан барих чадвараараа 4м зузаан бетонон ханатай тэнцүү байдаг.



Сэргээгдэх эрчим хүч: Нар, салхи, усыг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааг хэлнэ. Монголд хамгийн ашиглах боломжтой сэргээгдэх эрчим хүч бол нарны эрчим хүч юм. Учир нь монгол улсад дунджаар жилд 230-260 өдөр өөрөөр хэлбэл 2600-3300 цаг үүлгүй нарлаг өдрүүд байдаг байна.

буй байшингийн агааржуулагч, халаалтын системийг ажиллуулах, гэрэлтүүлэх, компьютерийг ажиллуулахад хангалттай эрчим хүч гаргадаг.

Ийм төрлийн эрчим хүчний эх үүсвэр нь агаарын бохирдлыг бууруулахад ашиг тустай.




УСАА ХЭМНЭХ БА ДАХИН АШИГЛАХ

Усны үр ашиг: Усны үр ашиг гэдэг нь бага ус ашиглан өөрт авдаг хэрэглээгээ тэр түвшинд авах гэсэн ойлголт юм.

Борооны ус: Борооны ус бол байгалийн цэвэр усны үнэгүй нөөц юм. Хэрэв та хөдөө орон нутгаар амьдардаг бол борооны усыг тосч ашигласанаар таньд усны зардалаа хэмнэхэд ихээхэн тус болно.



МОД ТАРИХ



ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ, ДАХИН АШИГЛАХ

Бид ахуйн хаягдлын хэмжээг багасгаж, ухаалаг худалдан авалт хийх шаардлагатай. Сав, баглаа, боодол, гялгар уутнаас татгалзан дахин боловсруулагддаг бүтээгдэхүүнийг ахуйн хэрэглээндээ сонгосноор та хүлэмжийн хийн ялгаралтыг багасгахын хажуугаар, өөрийн эрүүл мэнд, хот суурийн газрын тохижилтод өндөр хувь нэмэр оруулах болно.



Хог хаягдлыг багасгах, дахин ашиглах

4Э зарчим гол байр суурь эзлэнэ.

(Эрс багасагах,


Эдэлгээг уртасгах,

Эргүүлж ашиглах,

Эргүүлж боловсруулах)

4Э зарчмыг хэвшүүлэх шаардлагатай байна.

Ухаалаг зорчилт



АВТОМАШИН

Хэрэв та шинэ машин худалдан авах гэж байгаа бол Гибрид хөдөлгүүрт болон цахилгаан хөдөлгүүрт машиныг сонгох нь таны урсгал зардлыг хэмнэхийн зэрэгцээгээр байгаль орчин, агаарын бохирдлыг бууруулах том алхам юм. Хэрэв та 2 болон түүнээс дээш тооны автомашин унадаг бол цөөлөх талаар бодоорой.

Ухаалаг зорчилт

Унадаг дугуй



Унадаг дугуйгаар зорчих

Дугуйгаар явах нь таны тээвэрийн зардлыг багасгах үр ашигтай арга бөгөөд байгаль орчинд ямар ч хор хөнөөл учруулахгүй. Мөн таны эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх болно.



Хэрэв та дугуйг байнга ашиглах боломжгүй байлаа ч ойрхон явах замдаа ашиглаж болно.

Ухаалаг зорчилт

АЛХАХ

Алхах нь зүрх судасны өвчинөөс сэргийлэх бас нэгэн арга юм. Хүүхэдтэйгээ сургууль руу нь, гэрлүүгээ алхаж хэвших нь хүүхдэд эрүүл мэнд, жингийн асуудалын хувьд маш сайн үр дүнтэй.







АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА